



ЭЕРЭГ НӨЛӨӨ БҮТЭЭСЭН 2023 ОН

2024 оны 4-р сар
Улаанбаатар хот

ЛОРИНЭТ САНГИЙН ТУХАЙ

ЭРХЭМ ЗОРИЛГО

Лоринэт Сан нь Монгол Улсад туслалцаа дэмжлэг шаардлагатай байгаа хүүхэд залуус, айл өрхүүдийн амьдралд тогтвортой, эерэг өөрчлөлтийг бий болгох үндсэн зорилготой.

НИЙГМИЙН ҮР НӨЛӨӨ

Бид дараах хоёр түвшинд нийгмийн үр нөлөө (social impact)-г бий болгохыг зорин ажилладаг. Үүнд:

- Бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсрол болон Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэнээр гарах **ШУУД ҮР НӨЛӨӨ**
- Холбогдох мэдлэг, мэдээллийг боловсруулан түгээж, олон талт хамтын ажиллагааг бэхжүүлж, урт хугацааны тогтвортой үр өгөөж авчирдаг сайн туршлагуудыг тогтолцоонд нэвтрүүлснээр бий болгох **СИСТЕМИЙН ТҮВШНИЙ ҮР НӨЛӨӨ**

ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ БУЙ ЧИГЛЭЛҮҮД

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН АСАРГАА ХАЛАМЖ, БОЛОВСРОЛ

Бага насны хүүхдүүдэд асран халамжлуулах, насандаа тохирсон эрт үеийн боловсрол эзэмших боломжийг бий болгох.

ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Залуучуудад тогтвортой хөдөлмөр эрхлэх, орлого болон амьдралын чанараа сайжруулах боломжийг бий болгох.

ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ БУЙ АРГАЧЛАЛ

Лоринэт Сан нь Монгол Улсад нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх шинэлэг арга аргачлал нэвтрүүлж буй төсөл хөтөлбөрүүдийг сонгон шалгаруулж, тэдгээрийг хэрэгжүүлдэг байгууллагуудад санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх замаар нийгмийн үр нөлөө бий болгодог.

2023 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

- Бүтээж буй нийгмийн үр нөлөөгөө үнэлэх, мэдээлэх арга аргачлалаа боловсронгуй болгож, **ШУУД** болон **СИСТЕМИЙН ТҮВШНИЙ ҮР НӨЛӨӨ**-г хэмжих аргачлалыг боловсруулсан.
- Ийнхүү тодорхойлсноор 2018-2022 оны хооронд хийж бүтээсэн ажлаа эргэн дүгнэх нөхцөлийг бүрдүүлж, **“Эерэг нөлөө бүтээсэн 5 жил”** нийгмийн үр нөлөөний тайлангаа нийтэлсэн. [Уг тайлангийн бүрэн эхийг эндээс уншина уу.](#)
- Өнгөрсөн хугацаанд хийж бүтээсэн ажлаасаа тасралтгүй суралцаж, сангийн түвшний стратегиа мөн шинэчиллээ. **“Сайн туршлагыг тогтолцоонд нэвтрүүлэх нь”** гэх шинэчилсэн стратегитай [эндээс танилцана уу.](#)
- Мөн түүнчлэн дэмжин ажилладаг **үндсэн чиглэлүүдийн стратегийг** улам боловсронгуй болголоо. Үүнд:
 - **Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн** чиглэлд залуучуудад ур чадвар олгохоос гадна тэдгээрийг боловсролоос хөдөлмөр эрхлэлт рүү шилжихэд нь дэмжлэг үзүүлж, хөдөлмөр эрхлэхэд таатай экосистемийг бүрдүүлэхийг зорино.
 - **Бага насны хүүхдийн хөгжлийг** дэмжих чиглэлд насанд тохирсон эрт үеийн боловсрол олгохоос гадна асран, халамжлуулах нөхцөл, боломжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэв.
 - **Үндсэн хоёр чиглэлээ нэгтгэн**, залуу ээжүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэнгээ тэдгээрийн бага насны хүүхдүүдэд асран халамжлуулан, эрт үеийн боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэхийг мөн зорин ажиллахаар шийдвэрлэлээ.
- Гадаад дотоодын **оролцогч талуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа улам бэхжүүллээ.** Үүнд:
 - Олон улсад, Skoll, Yidan, AVPN, GECF, IEFG, ARNEC, ISSA зэрэг платформуудад болон зарим сангуудтай харилцаа холбоогоо бэхжүүллээ.
 - НҮБ-ын Хүүхдийн Сантай хамтран “Монголын бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээ”-ний үйл ажиллагааг үргэлжлүүлэн удирдан зохион байгуулж байна.
 - Хувийн хэвшлийн оролцогч талуудтай харилцаа холбоогоо нэмэгдүүлэх зорилгоор Америкийн Худалдааны танхимын Монгол дахь салбар ([АМЧАМ](#))-т гишүүнээр элсэв.
 - Манай сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгждэг “Хамтдаа Уншицгаая” төсөл нь АМЧАМ-ын Нийгмийн үр нөлөөний шагналын инновацын төрөлд шалгарсан нь уг төслийн үнэ цэнийг дахин бататгасан үйл явдал боллоо.

- **Мэдлэг бүтээх, хуваалцах** зорилгын хүрээнд бид “Олон улсын бага насны хүүхдийн боловсролын хөтөлбөрүүдийн сайн туршлага” судалгааны үр дүнгээ салбарын оролцогч талуудтай хуваалцсан бөгөөд олон улсын донор байгууллагуудаас өндөр үнэлгээ авлаа. [Судалгааны хураангуй](#)
- **Сангийн хамт олны** мэдлэг, ур чадварыг улам сайжруулах чиглэлээр ажилласан ба Жессика Хжарранд (Jessica Hjarrand) болон Дүгэрээгийн Заяасайхан зөвлөхүүд маань өөрсдийн үнэ цэнтэй мэдлэг туршлагаа бидэнтэй хуваалцсаар байна.
- Мэдээлэл харилцааг илүү сайжруулах зорилгоор сангийн **вэбсайтыг** шинэчиллээ.
- Бид дэмжлэг үзүүлж буй үндсэн чиглэлүүдийнхээ хүрээнд шууд хөрөнгө оруулалт хийгээд зогсохгүй **Монгол Улс руу нэмэлт санхүүжилт, хөрөнгө нөөцийг татан төвлөрүүлэх** чиглэлд ажиллахаар мөн шийдвэрлээд байна.



НИЙГМИЙН ШУУД ҮР НӨЛӨӨ

2023

онд хийсэн грант
санхүүжилтийн үр
шимийг хүртсэн
хүний тоо

5,254

бага насны хүүхэд

605

эцэг, эх асран
хамгаалагч

385

бага насны
хүүхдийн асаргаа
халамж, эрт үеийн
боловсролын
үйлчилгээ үзүүлэгч

ГРАНТ САНХҮҮЖИЛТИЙН ОНЦЛОХ ҮР ДҮНГҮҮД

2023 оны хувьд манай сан менежментийн багийн ур чадвараа ахиулах, стратегиа шинэчлэх ажлуудад төвлөрөн ажилласан нь дараагийн 5 жилийн үйл ажиллагааны чиглэлийг нарийвчлан тодорхойлоход үнэтэй хувь нэмэр орууллаа. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлд бидний санхүүжүүлсэн анхны төсөл хөтөлбөрүүдийн эхний үе шатууд дуусаж, шинэ төсөл хөтөлбөрүүд сонгон шалгаруулах тал дээр анхааран ажиллалаа. Харин Бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсролыг дэмжих чиглэлд олон жил дэмжин ажиллаж буй Азийн Сан болон Уанскай байгууллагуудын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд дараах эерэг үр дүнгүүд гаргасаар байна. Үүнд:

- Бага насны хүүхдүүд эдгээр хөтөлбөрүүдээс үр шим хүртэж тэдний хөгжил дэмжигдсээр байна.
- Эцэг эх, асран хамгаалагчдын мэдлэг, ур чадварын түвшин нэмэгдсэнээр тэдгээрийн зан үйлд эерэг өөрчлөлт гарч байна.
- Асаргаа халамж, эрт үеийн боловсролын үйлчилгээ үзүүлэгч нарын чадавх сайжирсаар байна.
- Төсөл хөтөлбөрүүд маань Монголын бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсролын салбарт танигдан хүлээн зөвшөөрөгдсөнөөр төр болон хувийн хэвшилтэй хамтын ажиллагаа амжилттай өрнүүлж байна.

Бид дэмжиж буй төсөл хөтөлбөрүүдийнхээ бодит үр нөлөөг үргэлжлүүлэн хэмжихээс гадна цар хүрээг нь тэлэх, тогтвортой хэрэгжих нөхцөлийг бүрдүүлснээр системийн түвшний үр нөлөө авчрах арга замуудыг эрэлхийлэн ажилласаар байна.

ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ НАРЫН ХҮҮХДЭЭ АСРАН ХАЛАМЖЛАХ УР ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА:
УАНСКАЙ МОНГОЛ



Уанскай байгууллага нь Улаанбаатар хотын бага насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч нарт хүүхдээ асран халамжлах мэдлэг, ур чадвар олгох сургалтын хөтөлбөрийг Гэр бүлийн төвөөрөө дамжуулан зохион байгуулахаас гадна, хөршийн холбоог бэхжүүлж, бага насны хүүхдүүдэд тоглонгоо хөгжих ээлтэй орчин, боломжийг бүрдүүлэн өгч байна.

2023 онд Уанскай нь Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдийн холбоо зэрэг байгууллагуудтай амжилттай хамтран ажиллаж, бага насны хүүхдийн хөгжлийн салбарт мэдэгдэхүйц орон зайг эзэлж чадлаа. Одоогоор Уанскай нь Монгол Улсад дараагийн 3 жилд хэрэгжүүлэх стратеги төлөвлөлтөө боловсруулж байгаа бөгөөд 2023 оны хувьд дараах үр дүнг гарган ажиллалаа. Үүнд:

- **386 эцэг эх, асран хамгаалагчийн** хүүхдээ асран халамжлах мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлж, **3,741 хүүхдэд** эергээр нөлөөлсөн байна.
- Цэцэрлэгийн багш, төрийн бус байгууллагын ажилтнууд, хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгч нар зэрэг **192 бага насны хүүхдийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэгч, мэргэжилтнүүдийн** чадавхыг бэхжүүлсэн байна.
- Гэр хороололд үйл ажиллагаа явуулдаг **15 улсын цэцэрлэгтэй хамтран ажиллаж**, цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагч нарт мэдлэг, ур чадвар олгох сургалтын хөтөлбөрөө зохион байгуулан ажиллав.
- Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэгт багтаж, мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлсэн. Мөн түүнчлэн Монгол Улсад зохион байгуулагдсан Бага насны хүүхдийн цогц хөгжлийн үндэсний чуулган болон Филиппин Улсад болсон Ази, номхон далайн бүсийн бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээний чуулганд оролцож, мэдлэг туршлагаа хуваалцан, **төрийн байгууллагууд болон бусад оролцогч талуудтай хамтын ажиллагаагаа тэлсэн** байна.
- Монгол Улсад анх удаа **хөрөнгө босгох үйл ажиллагаа зохион байгуулж**, 40 гаруй хувь хүн, компанийн төлөөллийг урин, нийт 40,000 ам. доллар татан төвлөрүүлсэн байна.

Онцлох үйл явдал: Энэ онд Уанскай нь эцэг эх, асран хамгаалагчдыг чадавхжуулах сургалтын цөм хөтөлбөрөө сайжруулж, Гэр бүлийн төвөөс гадна ойролцоох улсын цэцэрлэгүүдээр дамжуулан сургалтын хүртээмжээ нэмэгдүүлсэн. Мөн Уанскай нь хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгч нар болон төрийн байгууллагуудтай амжилттай хамтран ажиллаж, хүүхэд харах хувилбарт үйлчилгээний шилдэг загварыг хөгжүүлэхээр ажиллаж байна.

НОМООР ДАМЖУУЛАН БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ НЬ

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА:
МОНГОЛ ДАХЬ АЗИЙН САН



The Asia Foundation

Хамтдаа Уншицгаая нь эцэг эх, асран хамгаалагч болон багш нарт бага насны хүүхдэд эрт үеэс ном уншиж өгөхийн ач холбогдлыг таниулах, Монгол хэл дээрх хүүхдийн ном, номын өдөрлөгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой цогц хөтөлбөр юм.

Азийн Сан нь 2023 онд олон нийтийн компанит ажил, үлгэрийн цаг, сайн дурын уншигчийн клуб, хувийн хэвшлийн компанийн ажилтнуудад сургалт орох, хүүхдийн ном бүтээх уралдаан зарлах зэрэг олон төрлийн ном унших соёлыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна.

- 177 удаагийн “үлгэрийн цаг” ном унших арга хэмжээг орон нутгийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран, улсын номын сан, олон нийтийн төв, бусад нийтийн зориулалттай байршлуудад зохион байгуулж, нийт **2,377 хүүхдэд** хүрч ажилласан байна (үүнээс **1,513 нь 0-6 насны хүүхдүүд**).
- **219 эцэг эх, асран хамгаалагч болон 193 цэцэрлэгийн багш** нарт ном унших ач холбогдол, аргазүйн талаарх сургалт зохион байгуулсан байна.
- Хүүхдийн номын зохиолч, зураачдад зориулсан гурван сарын чадавх бэхжүүлэх хөтөлбөр зохион байгуулж, **Монгол зохиолчдын 4 хүүхдийн номыг шинээр бүтээж**; Англи хэл дээр бичигдсэн 66 хүүхдийн номыг Монгол хэл рүү орчуулан; 5 хүүхдийн номыг 5,000 хувь хэвлэн тараасан байна.
- Хүүхдэдээ багаас нь ном уншиж өгөх, өдөр бүр ном унших ач холбогдлыг таниулах, **олон нийтийн мэдлэг ойлголтыг сайжруулах зорилготой ‘Ирээдүйнх нь төлөө 15 минут’ цахим аяны** хүрээнд 77 зураглал пост бэлтгэж, 12 подкаст видео бүтээж, богино хэмжээний 40 ангит телевизийн нэвтрүүлэг бэлтгэн, эдгээр нь нийт 1.5 сая хандалт авчээ.
- **Цахимаар ном унших үнэгүй апп** (Let's Read)-ыг сурталчилснаар тус апп нь 10,899 удаа татагдсан бөгөөд эдгээр хэрэглэгчдийн 50% нь апп-ыг тогтмол хэрэглэж байна.

Онцлох үйл явдал: Азийн Сан нь Монгол Улсад анх удаа Хүүхдийн номын зохиолч, зураачдад зориулсан чадавх бэхжүүлэх хөтөлбөрийг санаачлан амжилттай зохион байгууллаа. Туршлагатай номын зохиолч болон хэвлэлийн мэргэжилтнүүд тус санаачилгыг дэмжин ажилласан бөгөөд нийт 16 уран бүтээлчийн чадавхыг бэхжүүлснээс 3 нь өөрсдийн хүүхдийн номоо бүтээж, 4 оролцогч нь олон улсад өөрсдийн бүтээлээ гаргахаар зэхэж байна.

СИСТЕМИЙН ТҮВШНИЙ ҮР НӨЛӨӨ

- Монгол Улсын төрийн албан хаагчдыг Вьетнам Улсын туршлагаас судлахад дэмжлэг үзүүлсэн нь

Бид Уанскай байгууллагатай Монгол болон Вьетнам Улсад хамтран ажилласан туршлагаа түшиглэн Монгол Улсын холбогдох төрийн албан хаагчдыг Вьетнам Улс руу [сайн туршлага судлах аялал](#) зохион байгуулахад дэмжлэг үзүүллээ. Тус аяллаар Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн холбогдох төрийн албан хаагчид Уанскайн Вьетнам дахь хөтөлбөртэй танилцахаас гадна тус улсын Боловсрол сургалтын яамны Бага насны хүүхдийн хөгжлийн газрын дарга мэргэжилтнүүдтэй туршлага солилцох албан уулзалтууд хийсэн юм.

Энэхүү аялал нь хүүхэд харах хувилбарт үйлчилгээг төр, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд амжилттай хэрэгжүүлж буй туршлагаас суралцахаас гадна Монголын Улсын холбогдох бодлогын баримт бичгийг сайжруулахад чухал хувь нэмэр оруулсан юм.



- **Бага насны хүүхдийн хөгжлийн талаарх олон улсын мэдлэгийн санд хувь нэмрээ оруулсан нь**

Манай сангийн захиалгаар АНУ-д төвтэй Innovations for Poverty Action (IPA) байгууллагын хийж гүйцэтгэсэн “Олон улсын бага насны хүүхдийн боловсролын хөтөлбөрүүдийн сайн туршлага” судалгааны үр дүнг салбарын оролцогч талуудтай хуваалцлаа.

Судалгааны үр дүнг танилцуулах арга хэмжээ Австрали Улсын Мелбурн хотноо зохион байгуулагдсан Evidence and Implementation Summit 2023-ийн албан ёсны хөтөлбөрт багтсанаас гадна Global Early Education Funders Group (GEEFG)-ийн гишүүд хоорондын мэдлэг, туршлага солилцох арга хэмжээний үеэр мөн танилцуулагдсан юм. Бага насны хүүхдийн хөгжлийн чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч, санхүүжүүлэгч байгууллагууд тус судалгааны үр дүнг олон улсын мэдлэгийн санд оруулж буй хувь нэмрийг өндрөөр үнэлж нотолгоонд суурилсан хэрэгжилтийг эрхэмлэдэг аливаа оролцогч талд чухал ач холбогдол бүхий мэдлэгийн бүтээгдэхүүн болсныг онцлов. Судалгааны хураангуйг [эндээс уншина уу](#).

- **Монгол Улс дахь Бага насны хүүхдийн хөгжлийн экосистемийг бэхжүүлсэн нь**

Манай сан НҮБ-ын Хүүхдийн Сантай хамтран үүсгэн байгуулсан Монголын бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээ (МБНХХС) нь салбарын оролцогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, мэдлэг туршлагаа хуваалцах платформ болон хөгжиж байна.

2023 онд бид Ази Номхон далайн бүсийн бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээ (ARNEC) болон Network Impact байгууллагуудын хамтран зохион байгуулсан сүлжээний чадавх бэхжүүлэх цуврал сургалтад хамрагдсанаар МБНХХС-ний стратегийг эргэн дүгнэх, бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн тодорхойлох зэрэг сүлжээний үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Мөн түүнчлэн, бага насны хүүхдийн хөгжлийн ач холбогдлыг эцэг эх, асран хамгаалагч, олон нийтэд сурталчлан таниулах зорилго бүхий нийгмийн сүлжээний [пэйж хуудас](#) бүтээх ажлыг манай сан санхүүжүүлж ажиллалаа.

МБНХХС-ээс гадна бид холбогдох бодлогын баримт бичгийг боловсруулах ажилд хувь нэмрээ оруулж олон улсын сайн туршлагыг хуваалцан ажиллалаа. Тухайлбал ХНХЯ-ны урилгаар Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах ажлын хэлэлцүүлэгт оролцсон. Мөн түүнчлэн, олон улсын сайн туршлага болох Чили Улсын бага насны хүүхдийн хөгжлийн бодлого (Chile Crece Contigo)-ыг судлан, Монгол хэл рүү орчуулах замаар Монгол Улсын Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус зөвлөлийн ажилд дэмжлэг үзүүлээ.

ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАНААС ХОЙШ ОЛОН УЛСАД БОЛОН МОНГОЛД ОЛГОСОН ГРАНТ САНХҮҮЖИЛТЭЭС НИЙТ 51,374* ХҮН ҮР ШИМ ХҮРТЖЭЭ

Бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсрол

31,967

бага насны хүүхдийн чанартай асаргаа халамж, эрт үеийн боловсролд хамруулсан 0-5 настай хүүхдийн тоо

2,209

чадавхжуулах сургалтад хамрагдсан эцэг эх, асран хамгаалагчдын тоо

59%

ур чадвар нь нэмэгдсэн хэмээн мэдүүлсэн эцэг эх, асран хамгаалагчдын эзлэх хувь

1,840

чадавх бэхжүүлэх сургалтад хамрагдсан бага насны хүүхдийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн тоо



*Ил тод нээлттэй байх зарчмаа баримтлан 2023 онд нийтэлсэн “Эерэг нөлөө бүтээсэн 5 жил” тайланд тооцооллын алдаа гаргаснаа хүлээн зөвшөөрч төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудынхаа тайлагналын хугацаа, стандартын зөрүүтэй байдлаас үүссэн асуудлыг шийдвэрлэсэн болохыг үүгээр мэдэгдэж байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт

3,890

хөдөлмөр эрхлэх болон өрхийн амьжиргаагаа дээшлүүлэхэд шаардлагатай ур чадваруудыг олгох сургалтад хамрагдсан залуучуудын тоо

79%

сургалтад хамрагдаад хөдөлмөр эрхлэлт рүү шилжсэн залуучуудын эзлэх хувь

80%

сургалтад хамрагдсанаар орлого эсвэл амьдралын чанар нь сайжирсан хэмээн мэдүүлсэн залуучуудын эзлэх хувь

222

ажиллах хүчний чадавхыг бэхжүүлэхэд хамтран ажилласан ажил олгогч, төрийн байгууллагын албан хаагчдын тоо



ЦААШДЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 онд бид өнгөрсөн 5 жилийн жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлаа эргэн дүгнэж, дараагийн 5 жилийн стратегийн чиглэлийг нарийвчлан гаргалаа. Цаашид бид **“Сайн туршлагыг тогтолцоонд нэвтрүүлэх нь”** гэх стратегийг баримтлах бөгөөд дараах үндсэн таван чиглэлийн хүрээнд ажиллана. Үүнд:

Нийгмийн хөрөнгө оруулалт хийх

Бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсрол, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт болон Нэгдмэл үндсэн чиглэлүүдийнхээ хүрээнд грант санхүүжилт үргэлжлүүлэн олгож, грант менежментийн системээрээ дамжуулан төсөл хөтөлбөрүүдээ хянаж, зорилтот үр дүнд хүрэхийн төлөө ажиллана.

Мэдлэг бүтээх, хуваалцах

Сэдэвчилсэн судалгаа болон санхүүжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн үр дүнгээс тасралтгүй суралцахаас гадна бусад оролцогч талуудын ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн **мэдлэг, мэдээлэл үргэлжлүүлэн түгээн дэлгэрүүлнэ.**

Экосистемийг бэхжүүлэх

Төсөл хэрэгжүүлэгч хамтрагч байгууллагуудынхаа чадавхыг бэхжүүлэх чиглэлийг үйл ажиллагаандаа албан ёсоор нэвтрүүлж, төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлнэ.

Хөрөнгө татан төвлөрүүлэх

Бүтээж буй нийгмийн үр нөлөөний цар хүрээг тэлэх зорилгоор бусад ижил төстэй сан, хувь хүн, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран, **Монгол Улсад нийгмийн хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлэх ажлыг эхлүүлнэ.**



Бодлогын орчин, тогтолцоог бэхжүүлэх

Төсөл хөтөлбөрүүдийнхээ тогтвортой байдал, урт хугацааны үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор холбогдох төрийн байгууллага болон бодлогын орчин тодорхойлох тогтолцооны оролцогч талуудтай ойр ажиллахыг эрэлхийлнэ.


Сайн
туршлагыг
тогтолцоонд
нэвтрүүлэх
нь

ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУД

Экосистемийн хамтрагчид



Төсөл хэрэгжүүлэгч хамтрагчид



Манай сангийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл авах эсвэл бидэнтэй хамтарч ажиллахыг хүсвэл дараах хаягаар холбогдоно уу
<https://www.lorinetfoundation.org/contact/>